

Бэрс гарлаа

Бэрс тоглоомыг хэзээ ч эхлүүлдэггүй, гэхдээ тоглоомонд маш чухал нүүдлүүдийг хийдэг.



Binance Smart Contract

Solana Blockchain

Блокчэйн бол ирээдүй.



Бэрс койн

2021 5 сарын 18 - 2021 10 сарын 24

Whitepaper

v1.2

Бэрс койны whitepaper тухлан сууж уншина уу

[Англи дээр унших бол энд дарна уу.](#)

[Франц дээр унших бол энд дарна уу.](#)



Агуулга

| | |
|---|-----------|
| Танилцуулга | 4 |
| Асуудал..... | 5 |
| Шийдэл | 6 |
| Хэрэглээний жишээ..... | 7 |
| Бэрс койн..... | 10 |
| Бэрс- BERS койн гэж юу вэ? | 10 |
| Бэрс койны хуваарилалт | 12 |
| Бэрс койныг хэрхэн хаанаас авч болох вэ? | 13 |
| ICO/IEO and Airdrop: | 17 |
| Дүгнэлт | 18 |



Танилцуулга

Бэрс койн нь Блокчэйн дээр Бинанс ухаалаг гэрээгээр баталгаажин ажилладаг крипто токен юм.

| | |
|------------------------------|--|
| Үндэслэгч | Bers Technology LLC |
| Төрөл | Крипто токен |
| Нэр | Бэрс |
| Токен тикер | BERS |
| Вэбсайт | www.berscoin.com |
| Блокчэйн | Binance Smart Contract + Solana |
| Токен стандарт | BEP20 |
| Нийт нийлүүлэлт | 4,000,000,000 |
| Токен нэгж үнэ \$ USD | 0,00060 |
| Токен нэгж үнэ ₮ MNT | 1,77 |
| Олборлож болох эсэх | Олборлогдохгүй |

Блокчэйн дээрх гэрээг шалгаж үзэх бол энд дарна уу
Гүйлгээнүүдийг илүү хямд, хурдан хийхийн тулд бид Solana блокчэйнийг давхар ашиглаж байна.

Solana devnet :

<https://explorer.solana.com/address/DCEXw37nxoFTRmibtbEW4gnBijrqHPSyBt2VirUQYoXfX?cluster=devnet>

Solana mainnet :

<https://explorer.solana.com/address/5Rxq1GiVeuhhgcy3BEHLtjrHir1RKcNVpi5J6ZGMVDxi>



Асуудал

Бид эдийн засгийн маш тэнцвэргүй, монополчлогдсон нийгэмд амьдарч байна. Блокчэйн технологи дээр суурилсан төслүүд хүртэл эрүүл эко системийг бүтээж, ашиг орлогын тэнцвэртэй хуваарилалтыг хийхгүй байна. Блокчэйн дээр койн гаргаж цаасан мөнгөний дутагдлууд болон олон арван зардал ихтэй асуудлыг шийдэх зорилгоос хазайж цэвэр мөнгө олох, хэзээ худалдах, худалдан авах эсвэл тухайн койныхоо үнэ ханшийг янз бүрээр өсгөх дээр анхаарал хандуулан ажиллаж байна.

Яг адилхан дутагдалтай, эсвэл хэрэглэгчтэй ашгийг хуваах биш харин ч ил тод бус төвлөрсөн төслүүд их гарч байгаа юм. Мөн ашгаа нуухын тулд тухайн төслөө хүндрэлтэй, зардал ихтэй мэтээр харагдуулан төөрөгдүүлж байна.

Гэтэл үнэн хэрэгтээ Блокчэйн технологи нь зардал шимтгэл ихтэй итгэмжлэгдсэн гуравдагч этгээд дундын байгууллага, хамгаалалт сайтай бүртгэлийн дэд бүтэц, шилэн байдал гэх мэт асуудлуудыг маш сайнаар шийдсэн технологи юм.

Эрүүл эко системийг бий болгохын эсрэг ямар жишээнүүд байдгийг харцгаая:

- Төслийн ихэнх хувийг үүсгэн байгуулагчид түгжихгүйгээр эзэмших:

Асуудал: Энэ нөхцөлд койны үнийг хуурамчаар өсгөн их хэмжээгээр нийлүүлэлт хийн луйвар хийх эрсдэлтэй. Эсвэл нийлүүлэлт хийх үедээ ашгаа өөрсдөө хувааж авдаг.

- Бодит бус төсөл, хуурамч баг хамт олон, хөгжүүлэгчид:

Асуудал: Зардал бага бодит экосистем байхгүй харин койны үнэ өсгөх нь зорилго мэт олон нийтийн сүлжээ болон инфлүэнсэр-үүдийг ашиглан хуурамч итгэл төрүүлж үүн дээр ашиг хийдэг.

- Ашиг орлогын эх үүсвэр болон үйл ажиллагааны бүтэц нь нээлттэй бус:

Асуудал: Сайн төслүүд бий, гэхдээ бүх үйл ажиллагаа нь нээлттэй бус, зардлыг хүссэн үедээ нэмж ноогдол ашгаас нуух эсвэл ноогдол ашиг огт байхгүй.

- Нийлүүлэлтээ хязгааргүйгээр нэмж болох (mint) функц, хүчээр хомсдол үүсгэж шатаах (burn) функц :

Асуудал: Цаасан мөнгөний гол дутагдал нь хүсвэл хэвлээд л байдаг. Тэгвэл өөрийн гэсэн Блокчэйнгүй токен дээр **Mint** функц нэмвэл, хүссэн үедээ койны хэмжээг хэдээр ч нэмэгдүүлэх боломжтой болдог. **Burn:** Шинэ блок бүртээ урамшуулал болгон шинээр койн нь нэмэгддэг бол burn функц байх нь энгийн зүйл. Харин тогтсон хэмжээтэй мөртлөө burn хийх нь зөвхөн анхаарал татах, үнэ ханшид нөлөөлөх дээр ихэвчлэн ашиглагддаг. Эдгээр нь төсөлд маш хор нөлөөтэй юм.

Блокчэйн дээр олон олон койн гардаг боловч бүгд үнэ цэнэтэй биш. Харамсалтай нь олон хүмүүс төслийг сайн ойлгож судлахгүйгээр хөрөнгө оруулж эрсдэлд орж байна.




Эдгээр Блокчэйн дээрх койны асуудлуудаас гадна бидний анхаарлыг татаж байгаа нэгэн асуудал бол зар сурталчилгаа ба тэнд эргэлдэж байгаа төвлөрсөн ашиг орлого юм.

Өдөр бүр бид маш их мэдээ мэдээлэл, сошиал контентүүд үзэж хэрэглэдэг. Хэдийгээр мэдээлэл авах нь үнэгүй мэт боловч, үнэн хэрэгтээ тухайн мэдээллийг бид эхлээд ивээн тэтгэгчдийн контентүүд, зар сурталчилгаа **ЗААВАЛ** үзэж байж хэрэглэх боломжтой болдог. Хэрэглэгчийн ачаар энэ бүхний ард их мөнгө эргэлддэг ч хэрэглэгч ашгаас хүртдэггүй.

Энэ нь хэрэглэгчдийг эдийн засгийн эргэлтээс хасаж, энгийнээр бол хэрэглэгч тухайн системийн бүтээгдэхүүн болсон байдаг.

Нөгөө талаараа зар сурталчилгаа оруулагч тал ч бас хоосон маркетинг хийн үр ашиггүй мөнгө зарцуулдаг. Анхаарал татдаггүй зар сурталчилгаа, тоож харахаа больсон зарын байршлууд, эсвэл хэр их хүнд зар хүрсэн, хэр үр ашигтай байсныг нарийн тодорхойлох боломжгүй.



Эдгээр асуудлыг бүгдэд ашигтайгаар, Бэрс төсөл хэрхэн Блокчэйн ашиглан жинхэнэ экосистем бүтээх бэ?



Шийдэл

Төвлөрсөн бус платформууд нь Блокчэйн дээр суурилсан төрөл бүрийн санхүүгийн эрүүл эко системийг бий болгодог ба энэ нь ямар ч нууцлалгүй, криптограф болон урьдчилан нээлттэй бичсэн кодоор шалгагдаж хийгддэг.

Эдгээр платформууд нь мөнгөний зах зээлийн бүтцийг төв банк эсвэл хянан шалгах түвшний гуравдагч этгээдүүдээс хамааралгүйгээр гүйлгээг найдвартай бас хурдан хийдэг.

Тэгвэл бид Блокчэйнийг ашиглан бага үнэ өртөгөөр жинхэнэ эко системтэй платформуудыг бий болгож, ашгийг илүү ил тод тэнцүү хуваарилах боломжтой юм.

Бидний давуу талууд:

- Бид нийт койны 10 хувийг эзэмших ба бусад нөөцлөгдсөн койнуудтай хамт хугацаатай түгжсэн. Мөн үлдэгдэл нийлүүлэлтүүд (Liquidity), Бэрс төслийн нийт ашигт орох ба зах зээлд гадагшаа гарсан койн бүрээс ноогдол ашиг тараагдана.
- Нийт Бэрс платформуудаас орж ирэх бэрс койноос 50 хувийг хэрэглэгчдэд шууд өгнө. Мөн үлдсэн 50 хувийн цэвэр ашгаас койноо ноогдолд түгжсэн хэрэглэгчдэд ноогдол ашиг болгон хуваарилна.
- Платформ, Зар оруулагч, Хэрэглэгч гэсэн зар сурталчилгааны гурван талт системийг, аль аль талдаа маш ашигтайгаар өөрчлөн шинэчлэнэ.
- Блокчэйн дээр бүх гүйлгээ болон үйл ажиллагаа ил тод байна. Мөн Бэрс койны кодонд үнэ ханшид шууд нөлөөлөх нийлүүлэлтийг ихэсгэх (mint) эсвэл үнийн хүчилсэн өсөлтийг үүсгэх шатаах (burn) функцууд байхгүй.
- IEO дээр нэг хүн худалдан авах дээд хэмжээ 1 сая Бэрс буюу 1 777 000 төгрөг. Ингэснээр зах зээл дээрх тэгш хуваарилалт явагдах юм.
- Блокчэйн дээрх шилэн байдлыг ашиглан, тоглоом тоглон шагналын санг үүсгэх ба шилдэг тоглогчид болон тоглогч бүрт сонирхолтойгоор хуваарилалт хийх юм.

Энэ бүгдийн гаргалгаа нь юу вэ?



Хэрэглээний жишээ

Урамшуулал ба Контент: <https://reward.berscoin.com>

Жишээ нь :

Нэгэн албан байгууллага зар сурталчилгаагаа Бэрс платформ дээр оруулан жишээ нь 1,000,000 Бэрсээр цэнэглээд нэг хүнд урамшуулах койн 1 Бэрс гэж тохирууллаа.

Зар үзсэн хүн бүр тухайн үед нь шууд 1 Бэрс хүлээж авах ба нөгөө 1 бэрсийг Бэрс платформ авна.

Ингэснээр 500,000 өөр хүн зарыг үзэж цэнэг дуустал, хэдэн ч сараар хамаагүй платформ дээр зар идэвхтэй харагдана. Мэдээж орлого зарлага блокчэйн дээр шалгаж тулгаж болох зарчмаар ил тод хийгдэнэ.

Түүнчлэн зөвхөн хэрэглэгчийг дэмжих бус зар оруулагч талд ч гэсэн давуу талыг олгож байгаа юм:

Зарын үнэ төлбөр нь өдөр, хоног, сараар бус харин давхардаагүй үзсэн хүний тоогоор бодогдоно. Ингэснээр буруу үедээ зар оруулах, буруу газраа зар байрлуулах гэх мэт үр ашиггүй зар гэж байхгүй.

Түүнчлэн нэг хүнд өгөх бэрсийг ч зар оруулагч шийднэ. Хэрвээ Бэрс платформ 100,000 хэрэглэгчтэй гэж үзвэл та зараа бүх хүнд харуулахын тулд 200,000 Бэрс койн төлөхөд хангалттай гэсэн үг. Аль эсвэл урамшуулалд 0.01 бэрс өгнө гэвэл ердөө 2000 бэрс байхад л бүх хүн таны зарыг үзэх боломжтой. Мэдээж илүү өндөр урамшуулалттай зарууд платформын эхэн хэсэгт харагдана. Өндөр урамшуулалттай бол анхаарал татах нь ч ойлгомжтой байх.

Үүнээс гадна Бэрс контент бүтээгчдийн оруулсан бусад сошиал, youtube видео, аудио, зураг гэх мэт контентууд байрших болно. Эдгээр контентууд нь бусад зарын системээр санхүүжнэ. Ингэснээр та мөнгө олохын тулд зөвхөн зар үзэх бус, харин сонирхолтой мэдээ мэдээлэл, контент давхар үзэнгээ ашгаас хүртэх сайхан боломж юм.

Улирал бүр Бэрс платформ цугларсан бүх бэрс койны цэвэр ашгаас 80 хувийг нь ноогдол ашиг болгон « Цагаан Бэрс » -үүдэд тараана.

Цагаан Бэрс : Ноогдол ашиг авахаар койноо түгжсэн хэрэглэгч

Товчхондоо :





Ноогдол ашиг 80 хувь хэрхэн бодох вэ :

Эхлээд дээр хэлсэнчлэн, бүх Бэрс платформууд хэрэглэгчтэйгээ нийт цугларсан бэрс койныг 50/50 харьцаатай хувааж авна. Дараа нь Бэрс платформд үлдсэн 50 хувийн цэвэр ашгаас 80 хувийг нь Цагаан Бэрсүүдэд улирал бүр тараана.

$$\text{Ноогдол ашиг} = Y * U\% = Y * [(U * 100) / P]\%$$

Y бол Цэвэр ашгийн 80%

U бол Хэрэглэгчийн ноогдолд түгжсэн койн

P бол Нийт ноогдолд түгжсэн койн

U% бол Хэрэглэгчийн түгжсэн койны хувь = (Хэрэглэгчийн түгжсэн койн * 100) / Нийт түгжсэн койн

Жишээ тоонууд авч үзье:

Нийт 10 000 000 III койн эргэлдсэн гэж бодъё. 50 хувь нь хэрэглэгчдэд тухайн үед нь шууд оногдох учир нийт орлого 5 000 000 III болж үлдэнэ.

Үүнээс 50 хувь нь зардалд явна гэж үзвэл, цэвэр ашиг 2 500 000 III болно.

Цэвэр ашгийн 80 хувь гэхээр 2 500 000 III койноос 2 000 000 III үлдэнэ.

Хэрэглэгч зах зээлээс 10 000 III койн авч түгжсэн гэж бодъё.

Мөн бүх хэрэглэгчдийн нийт түгжсэн койн 10 000 000 III гэж үзвэл :

$$\text{Ноогдол ашиг} = 2\,000\,000 * [(10\,000 * 100) / 10\,000\,000]\% = 2000\ III$$

Өөрөөр хэлбэл та 10,000 Бэрс койн ноогдолд түгжихэд таны эдгээр койнууд таны төлөө ажиллаж өдөрт 22.22 койн олж байна гэсэн үг юм. (2000 ÷ 90 хоног).

Ийм ашиг, ноогдол ямар баталгаатай бэ?

Хэрвээ энэ төслийг Блокчэйн ашиглахгүйгээр хийвэл 50/50 болон 80 хувь өгнө гэсэн баталгаа хэзээ ч өгч чадахгүй. Батлах гэж зарлагандаа нүсэр их хамгаалалт хяналттай сервер, дэд бүтэц, ажилчин, хөгжүүлэгч, банканд төлөх зардал, аудит гээд л барагдахгүй их ажил, дуусашгүй их мөнгө хэрэгтэй болно.

Харин бид Блокчэйн хэмээх технологи эдгээрийг бидэнд найдвартайгаар шийдэж өгч байгаа юм:

- ✓ Төвлөрсөн бус
- ✓ Зогсолтгүй ажилладаг
- ✓ Гүйлгээний төлбөр хямд
- ✓ Хакердуулах боломжгүй
- ✓ Хүн бүхэнд нээлттэй
- ✓ Гуравдагч байгууллага, банк санхүүгийн оролцоогүй
- ✓ Хурдан ба ил тод
- ✓ Засаж нуух боломжгүй
- ✓ Хил хязгааргүй



Бэрс койн

Бэрс- BERS III койн гэж юу вэ?

Экосистем бүтээж үнэн зөвөөр ашгийг ил тод хуваахын тулд маш сайн хамгаалалттай бас хэн ч ороод шалгаж болох бүртгэл хэрэгтэй. Иймд Бэрс койн нь Бинанс ухаалаг гэрээгээр Блокчэйн дээр 2021 оны 5-р сарын 13-нд гарсан крипто токен юм.

Мөн хурд болон шимтгэлээрээ бусад бүх блоччэйнээс илүү дээр мөн дотоод гүйлгээг хийхээр хөгжүүлэлт явагдаж байна.

Solana devnet :

<https://explorer.solana.com/address/DCEXw37nXoFTRmBtbEW4gnBijrqHPSyBt2VirUQYoXfX?cluster=devnet>

Solana mainnet :


<https://explorer.solana.com/address/5Rxq1GiVeuhhgcy3BEHLtjrHir1RKcNVpi5J6ZGMVDxi>

Албан ёсны вэбсайт: <https://berscoin.com>

Бэрс койн нь Бинанс ухаалаг гэрээн дээр суурилсан учир, BEP20 протокол дээрх бүх хэтэвч дээр гүйлгээ хийх боломжтой.

- Жишээ нь: Trust Wallet, Metamask, Phantom

Хэрхэн Бэрс койн эргэлдэх бэ?





Баг хамт олон ба үүсгэн байгуулагчид

Бэрс койныг үүсгэн байгуулагч Нармандах Монблон нь IT инженерээр 2011 онд Франц улсад суралцаж төгссөн ба тухайн улсдаа одоогоор Indépendance Royale компанийн СТО (Chief Technical Officer), IT хөгжүүлэлтийн багийг удирдан ажиллаж байна. Тэрээр 2015 онд анх биткойн олборлож эхэлснээр крипто ертөнцөд хөл тавьсан бөгөөд Bitfinex болон Kraken гэх мэт крипто биржүүд дээр арилжаа хийж эхэлжээ. Мөн ухаалаг гэрээг сонирхон тэст койнууд гарган, төвлөрсөн бус программын хэл Solidity-г сурч эзэмшжээ. Тэрээр мөн 2017 онд Youtube дээр Биткойн гэж юу вэ, Блокчэйн хэрхэн ажилладаг вэ гэх мэт видео бичлэгүүдийг Монгол хэлээр олонд хүргэж байсан.

Баг хамт олон :



**Narmandakh
Montblanc**

CEO

IT Engineer, Apps
Developer



**Temuujin
Chinbaatar**

COF

Digital Marketing
engineer



**Jean-François
Cane**

CTO

Smart contract, DeFi
Expert



Enkhtur Natsag

Head of Sales and
Partnership

CEO of MIMICO



**Thomas
BASCOUL**

Software Engineer



**Delgermaa
Batsaikhan**

Frontend Engineer



Nomin Bold

Business Strategist



**Enkhmaa
Munkhjargal**

Community Lead

Баг хамт олны сурсан сургууль, мэрэгжил дэлгэрэнгүй мэдээллийг сайт дээрээс авна уу.



Бэрс койны хуваарилалт

Бэрс койн хасаж нэмэх боломжгүйгээр 4 тэрбум ширхэг гарсан. Зөвхөн хэрэглэгч буруу блокчэйн хаяг руу койноо илгээсэн тохиолдолд нийт нийлүүлэлт буурах магадлалтай.


| | | |
|---------------------------------|-----|---------------|
| Баг хамт олон* | 10% | 400,000,000 |
| Нөөцлөл* | 10% | 400,000,000 |
| ICO/IEO & Airdrop | 15% | 600,000,000 |
| Хөрөнгө оруулагчид ба маркетинг | 15% | 600,000,000 |
| Үйл ажиллагаа | 20% | 800,000,000 |
| Хөрвөх чадвар ба нийлүүлэлт* | 30% | 1,200,000,000 |
| | | 4,000,000,000 |

Баг хамт олон*: Шууд зарж болохгүйгээр түгжигдсэн ба жил бүр 25 хувиар нээгдэнэ.

Нөөцлөл*: 5 жилээр түгжигдсэн.

Хөрвөх чадвар ба нийлүүлэлт (Liquidity)*: Зах зээл дээр нийлүүлэлт хийх тохиолдол бүрт орсон орлого нь, Бэрс төслийн ашигт тооцогдох ба ноогдол ашиг 80 хувийн дүрмээр Цагаан Бэрсүүдэд тараагдана. Учир нь энэ нийлүүлэлт нь Бэрс хэрэглэгчдийн хөрөнгө гэж бид үзэж байна.

Хамгийн эхний IEO болох 400 сая Бэрс койныг дотоод биржүүд дээр 2021 4-р улиралд гаргахаар ажиллаж байна.



■ Баг хамт олон*

■ Нөөцлөл*

■ ICO/IEO & Airdrop

■ Хөрөнгө оруулагчид ба маркетинг

■ Үйл ажиллагаа

■ Хөрвөх чадвар ба нийлүүлэлт*



Бэрс койныг хэрхэн хаанаас авч болох вэ?

- ICO болон IEO-д оролцох
- Бидэнтэй нэгдэн, төслүүд дээр хувь нэмэр оруулж хамтарч ажиллах
- Урамшуулалттай платформ дээр контент болон зар сурталчилгаа үзэх : <https://reward.berscoin.com>
- Бэрс тоглоом дээр шилдэг нь байж Бэрс шагналын сангаас хожих: <https://games.berscoin.com>
- IEO хийсний дараа :
 - o Бэрс хэтэвч дээр худалдан авалт хийх: <https://wallet.berscoin.com>
 - o PancakeSwap.finance дээр солилцоо хийх

замаар авч болно.

- Дотоод биржүүд дээр гаргах ажил явагдаж байна.





Төслүүд

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг төслүүдийн үндсэн сайт руу орж сонирхоно уу.

Бэрс хэтэвч: <https://wallet.berscoin.com>

Бэрс хэтэвчийн бүртгэлээр Бэрсийн бүх платформуудыг ашиглах боломжтой. Мөн койноо түгжин Цагаан Бэрс болж улирал бүрийн эцэст 80 хувийн ноогдол ашиг авах зориулалттай юм. IEO хийсний дараа танд аюулгүйгээр Бэрс койн худалдаж авах, зарах, шилжүүлэх эрх нээгдэнэ.



Wallet.
berscoin.com

Нүүр

Гүйлгээ


Авах

Зарах

500.00



Эхний 10,000 хэрэглэгчиддээ тус бүрт 500 Бэрс койн бэлэглэнэ.



Урамшуулал ба Контэнт: <https://reward.berscoin.com>

Хэрэглээний жишээ хэсгийг харна уу. (хуудас 8)


Гүйлгээнүүд Блокчэйн дээр зөвхөн Бэрс койноор явагдах учир, зах зээлийн үнээс хамаарч зарын урамшуулалд хэдэн бэрс койн өгөхийг зар оруулагч тал шийднэ.

Бид энэ платформуороо гадаад зах зээлд гарах ба Блокчэйний давуу талуудтай учир хүндрэл байхгүй гэж үзэж байгаа.



Бэрс Тоглоомууд: <https://games.berscoin.com>

Бэрс Шатар, Бэрс таавар, Бэрс пуужин гэх мэт тоглоом тоглож бонус Бэрс койн хожоорой. Мөн нийт шагналын санг шилдэг тоглогчид платформтой 50/50 хувиар тэнцүү хувааж авна.



Жишээ нь :

Шатар тоглоход төлбөрт нь 50 Бэрс койн гэж бодъё. Хожсон хүн өөрийн 50-н бэрсийг хожигдсон хүний 10 бэрстэй буцааж авна. Үлдсэн 40-н бэрсийн 20 нь шагналын санд, 20 нь платформд хуваарилагдана. Өдөрт дунджаар 100 тоглолт болдог гэж бодвол сард 3000 буюу 60,000 (3000 x 20) бэрс шагналын санд цуглана.


Нийт тоглолтын оноогоороо эхний 5т багтсан шилдэг тоглогч нар 60,000 бэрсийн 30 хувийг хувааж авах ба үлдсэн 70% хувийг нийт тоглосон бүх хүнд хуваана.

Нөгөө талаас платформд ноогдсон 60,000 бэрсээс цэвэр ашиг бодож дараагийн ноогдол ашигт орно гэдгийг дахин сануулъя.

Тоглолт тэнцвэртэй байхын тулд ойролцоо оноотой хүмүүс хоорондоо таарч тоглоно. Тэмцээнд орохгүйгээр тоглох тохиолдолд хэрэглэгчид хоорондоо үнэгүй тоглож болно.



Товчхондоо тоглолт бүрийн хуваарилалт:




Бэрс койны зах зээлийн үнээс хамаарч тоглоомын үнэ 50 төгрөгтэй тэнцэхээр өөрчлөгдөнө. Жишээ нь зах зээлд 1 Бэрс 5 төгрөг болвол тоглоом тоглох үнэ 10 бэрс болно гэсэн үг.

Энэ мэтчилэн тоглогч, платформ болон Цагаан Бэрс нар хамтдаа экосистем бүтээн ирээдүйн хөрөнгийг дундаа эзэмших сайхан боломж юм.



NFT: <https://nft.berscoin.com>

Бэрс NFT нь «цор ганц орлуулшгүй» бүтээлүүдээ бүх хэрэглэгчид болон дэмжигчиддээ зориулан гаргах гэж байна.



Манай баг хамт олон, өдөр бүр платформуудаа хэрэглэхэд хялбар болгохын төлөө шаргуу ажиллаж байна.



ICO/IEO and Airdrop:

Бэрс койны бүх нийлүүлэлтийн 15 хувь нь ICO, IEO болон airdrop-д хуваарилагдсан байгаа. Бид жил бүр гэнэтийн бэлэгтэй "айрдроп эвэнт" зохион байгуулна.

Удахгүй аль бирж дээр хэзээ IEO гарахыг дэлгэрэнгүй мэдээлэх болно.

Хэрэв та бидний төслийн талаар илүү их мэдээлэл авахыг хүсвэл Бэрс койны албан ёсны Facebook хуудас болон Youtube сувгийг дагаарай.

Дүгнэлт

Бэрс төсөл нь төвлөрсөн бус платформыг бий болгох, хэрэглэгчийн үйлдэл бүрийг шагнах, мөн ашгийг тэнцүү хуваан экосистемийг бүтээх зорилготой юм.

Бидний нүүдлүүд Блокчэйны хэрэглээний нэг жишээг авчирч, шинээр гарах койнуудад илүү чанартай болоход нь хувь нэмэр оруулна гэж итгэж байна. Энэ нь гоё сайхан койн гаргахдаа бус харин, асуудал болон зардлыг Блокчэйн дээр шийдэж хэрэглээндээ койн ашиглах ёстой гэдгийг ойлгуулах юм.

Түүнээс биш Блокчэйний шийдэл нь богино хугацаанд мөнгө олох, хямдхан авч дараагын хүндээ үнэтэй зарах мэт сүлжээ биш харин ирээдүй юм. Тоглоомонд Бэрс нүүх цаг иржээ. Та харин бидэнтэй нэгдэхэд бэлэн үү?

Сайн төслийн хэрэглээ өдөр ирэх тусам ихсэж, үнэ өсдөг нь зах зээлийн дүрэм билээ. Бид цаашдаа Блокчэйн ашиглан олон шинэ Бэрс төслүүд гаргах ба бусад Блокчэйн төслүүдтэй дуртайяа хамтран ажиллана. Блокчэйн мандтугай !

Хэрэв та мэдлэг чадвараараа хамтрахыг хүсвэл бидэнтэй заавал холбогдоорой.

Өөрчлөлт хийхийн тулд
Дараагийн алхмуудыг хамтдаа
хийцгээе.

www.berscoin.com



*Та хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө зохих
судалгаа хийх эсвэл санхүүгийн зөвлөлгөө
заавал авахыг Бэрсийн хамт олон зөвлөж
байна.*